

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 01.080.10

Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага	MNS 7023:2023
Requirements for the displaying information on construction works to be financed by state, local government budget and foreign loans and aid on bulletin board	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн С/49 дүгээр тушаалаар батлав.

Энэ стандартыг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр улсын бүртгэлд бүртгэв.

Энэ стандартыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандартаар улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын ажил бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд хэрэглэх мэдээллийн самбар байршуулах, тэдгээрийн нэгдсэн загвар, аргачлалыг тодорхойлно.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах хүчин төгөлдөр стандартыг эш татан ашигласан. Огноотой эшлэлүүдэд зөвхөн тухайн эшлэл авсан хэвлэлүүдийг, огноогүй эшлэлүүд нь хамгийн сүүлчийн хэвлэл болон хүчин төгөлдөр хувилбаруудыг тусгасан болно. Үүнд:

MNS 4596:2014, *Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм*

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

инженерийн барилга байгууламж

Барилгын тухай хуулийн 4.1.1, 4.1.33, 4.1.35, Эрчим хүчний тухай хуулийн 3.1.9, Авто замын тухай хуулийн 4.1.1, 4.1.11 дэх заалтууд;

3.2

мэдээллийн самбар

хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний ерөнхий мэдээллийг иргэдэд таниулах зорилготой байршуулсан мэдээлэл бүхий зурган самбарыг;

3.3

барилгын ажил

бүх төрлийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх талбайг бэлтгэх, бүрдэл хэсгийг угсрах, шинэчлэн барих, буулгах, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагаа;

3.4

гадна тохижилтын ажил

барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагаа.

4 Самбарын төрөл

Энэ стандартад төслийн мэдээллийн самбарыг зориулалтаар нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- a) Инженерийн барилга байгууламжийн барилгын ажлын самбар, 1-р зурагт үзүүлэв.
- b) Гадна тохижилтын ажлын самбар

5 Мэдээллийн самбарт тавих шаардлага

5.1 Мэдээллийн самбарт дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Ажлын нэр;
- Хөрөнгийн эх үүсвэр;
- Хүчин чадал;
- Захиалагч байгууллагын нэр, утасны дугаар;
- Гүйцэтгэгч байгууллагын нэр, утасны дугаар;
- Талбайн инженерийн нэр, утасны дугаар;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны нэр, утасны дугаар;
- Гэрээний үнийн дүн;
- Ажил эхлэх, дуусах хугацаа;
- Төсөл хэрэгжиж бий болох загвар зураг 3D;
- Бүтээн байгуулалтын загвар зураг.

5.2 Самбарын дэвсгэр өнгө нь цэнхэр, өнгийн код нь R-60 G-187 B-239, C-63 M-6 Y-0 K-0, үсгийн өнгө цагаан, код нь R-255 G-255 B-255, C-0 M-0 Y-0 K-06 байна.

5.3 Самбарын мэдээлэл Монгол хэл дээр байх ба олон улсын санхүүжилттэй хэрэгжиж буй төслийн хувьд англи хэл дээрх орчуулгыг 2 дахин бага хэмжээгээр бичнэ.

5.4 Самбарын тулгуур нь металл багана байна.

5.5 Мэдээллийн самбарт нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулж байна.

5.6 Самбарын мэдээлэлд нэмэх боломжтой агуулга болон самбарын материалыг 1-р хүснэгтэд үзүүлэв.

1-р хүснэгт - Самбарын мэдээлэл болон материал

Д/д	Төрөл	Мэдээлэл	Материал
1	Инженерийн барилга байгууламжийн барилгын ажил	Бүрэн хэмжээний загвар, барилгын ажлын зураг, төслийн орчны тойм зургийг том масштабаар үзүүлэх.	Металл төмөр хүрээтэй хулдаасан хэвлэл
2	Гадна тохижилтын ажил	Бүрэн хэмжээний загвар, гадна тохижилтын ажлын зураг, төслийн орчны тойм зургийг том масштабаар үзүүлэх	Металл төмөр хүрээтэй хулдаасан хэвлэл

5.7 Самбарын материал нь байгалийн үзэгдэлд тэсвэрлэхүйц зэвэрдэггүй, гандахгүй, шөнийн цагт саадгүй харагдах гэрлийн ойлтын тусгалтай байна.

5.8 Мэдээллийн самбарын бичвэр нь ирмэгээс дотогш тус бүр 20 см-ийн зайтай бичигдэнэ. Үсгийн бичвэр Roboto Condensed Bold фонтоор, үсгийн хэмжээ гарчигт 210 pt, бусад бичвэрүүд 140 pt хэмжээтэй байна.

5.9 Нэрийн бичвэр, тэмдэгтийн тоо, төсөл арга хэмжээнээс хамаарч самбарын хэмжээ нь 1.5 м × 2.2 м-ээс багагүй байна.

6 Самбарын байршил

6.1 Инженерийн барилга байгууламжийн барилга угсралтын ажлын самбарыг төслийн гадна нүүрэн талд нийтэд харагдахаар, дээд тал нь 3 м-ээс ихгүй өндөрт байршуулна.

6.2 Инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний ажлын самбарыг шугаман замын байгууламжийн эцэс төгсгөлийн цэгийг харуулсан байдлаар төслийн гадна нүүрэн талд нийтэд харагдахаар, дээд тал нь 3 м-ээс ихгүй өндөрт байршуулна.

6.3 Гадна тохижилтын ажлын самбарыг төслийн гадна нүүрэн талд нийтэд харагдахаар, дээд тал нь 3 м-ээс ихгүй өндөрт байршуулна.

6.4 Авто зам, их засвар шинэчлэлтийн барилгын ажлын самбарыг төслийн гадна нүүрэн талд нийтэд харагдахаар, дээд тал нь 3 м-ээс ихгүй өндөрт байршуулна. Шугаман замын байгууламжийн эцэс төгсгөлийн цэгийг харуулсан байдлаар, хэрэгжилтээс хамаарч иргэдийн зорчих хэсэгт өөрчлөлт орох бол орчны мэдээлэл, эргэх чиглэлд иргэдэд ойлгомжтой, саадгүй харагдах байдлаар авто замын тэмдэг тэмдэглэгээ, хашилт чиглүүлэх хэрэгслийг MNS 4596:2014, Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм стандартын дагуу нэмж байршуулна.

6.5 Самбарыг гаднын нөлөөлөлд тэсвэртэй, үзэгдэх орчныг хязгаарлахгүй, учирч болох эрсдэлийг тооцоолж суурилуулна.

MNS 7023:2023

6.6 Хэрэгжилтээс хамаарч иргэдийн зорчих хэсэгт өөрчлөлт орох бол орчны мэдээлэл, эргэх чиглэлд иргэдэд ойлгомжтой, чирэгдэлгүй, шуурхай байдлаар замын босоо тэмдгийг нэмж байршуулна. Энэ нь барилга угсралт болон тохижилт, засварын ажлаас бусад трасс бүхий ажилд хамаарна.

6.7 Мэдээллийн самбарыг трасс бүхий ажлын эхлэл, төгсгөлд нийтэд харагдахуйц ил тод байршуулна.

7 Дэлгэрэнгүй мэдээлэл

Төслийн дэлгэрэнгүй мэдээллийг А4 буюу 21х29,7см хэмжээтэй QR кодыг ашиглан электрон байдлаар хэрэглэгчдэд хүргэхээр самбарт нэмж тусгана.

Мэдээлэх самбарын загвар



1-р зураг - Инженерийн барилга байгууламжийн ажил



2-р зураг - Гадна тохижилтын ажил

ТӨГСӨВ.